

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/122/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/85
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ



19020302

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,155,240.73</u>	<u>26,563,033.26</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	22,155,240.73	26,563,033.26
351	Түүхий эд материал	2,614,332.00	2,614,332.00
35110	Тусгай зориулалттай материал	2,614,332.00	2,614,332.00
354	Хангамжийн материал	19,540,908.73	23,948,701.26
35410	Бичиг хэргийн материал	1,467,900.00	1,384,400.00
35420	Аж ахуйн материал	17,092,498.00	18,844,938.00
35460	Хүнсний материал	662,830.73	2,502,083.26
35470	Бусад хангамжийн материал	317,680.00	1,217,280.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>888,568,054.65</u>	<u>868,752,559.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	888,568,054.65	868,752,559.98
392	Биет хөрөнгө	868,568,054.65	848,752,559.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	836,479,822.95	836,479,822.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,828,709.11	-23,229,507.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,644,593.00	35,450,593.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,488,016.51	-14,716,422.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,656,056.66	24,420,273.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,608,003.14	-13,179,700.36
39217	Ном	3,712,310.80	3,527,500.00
393	Биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39301	Программ хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>910,723,295.38</u>	<u>895,315,593.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>36,000.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,000.00	00.00
413	Өглөг	36,000.00	00.00
4136	Бусад өглөг	36,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	36,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>910,687,295.38</u>	<u>895,315,593.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	910,687,295.38	895,315,593.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,704,995.45	77,704,995.45
51101	Өмч: - төрийн	77,704,995.45	77,704,995.45
512	Хуримтлагдсан үр дүн	799,289,129.90	783,917,427.76
51210	Өмнөх үеийн үр дүн	799,289,129.90	799,289,129.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-15,371,702.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,693,170.03	33,693,170.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>910,723,295.38</u>	<u>895,315,593.24</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,049,806,700.00	252,677,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	806,964,400.00	4,922,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	806,964,400.00	4,922,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	806,964,400.00	4,922,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	806,964,400.00	4,922,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,208,900.00	57,156,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	210,633,400.00	190,598,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,548,600.00	27,892,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,548,600.00	27,892,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,660,300.00	29,264,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,660,300.00	29,264,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	251,055,931.82	267,257,513.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,055,931.82	267,257,513.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,310,176.36	217,591,659.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,240,316.47	141,065,152.26
210101	Үндсэн цалин	89,540,564.40	101,655,058.00
210102	Нэмэгдэл	38,822,091.80	23,885,293.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,737,821.27	3,426,000.00
210104	Урамшуулал	8,139,839.00	12,098,801.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,572,072.07	18,701,975.06
210201	Тэтгэврийн даатгал	15,102,148.55	18,701,975.06
210202	Тэтгэмжийн даатгал	373,453.01	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	274,881.12	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	74,689.62	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	746,899.77	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,038,976.00	24,173,231.00
210301	Гэрэл, цахилгаан	1,298,651.00	1,016,091.00
210302	Түлш, халаалт	21,710,325.00	23,157,140.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	930,560.00	1,946,570.00
210401	Бичиг хэрэг	475,500.00	642,500.00
210402	Тээвэр, шатахуун	159,760.00	118,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56,500.00	475,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	238,800.00	630,900.00
2105	Нормативт зардал	9,174,935.84	8,583,625.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	45,000.00
210502	Хоол, хүнс	8,963,035.84	8,538,625.47
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	211,900.00	00.00

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	80,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	256,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,017,315.98	23,121,106.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	185,000.00	617,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,100.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,794,215.98	22,503,506.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,745,755.46	49,665,853.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,548,600.00	27,892,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,979,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,548,600.00	4,912,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,197,155.46	21,773,653.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,197,155.46	21,773,653.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	798,750,768.18	-15,371,702.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	791,988.64
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	791,988.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	798,750,768.18	-15,371,702.14

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	1,166,561.72	112,564,727.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	1,166,561.72	112,564,727.20
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	798,122,568.18	798,122,568.18
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	799,289,129.90	910,687,295.38
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	799,289,129.90	910,687,295.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	799,289,129.90	910,687,295.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,371,702.14	-15,371,702.14
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	783,917,427.76	895,315,593.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	242,842,300.00	247,755,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	242,842,300.00	247,755,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	210,633,400.00	190,598,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,548,600.00	27,892,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,548,600.00	27,892,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,660,300.00	29,264,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,660,300.00	29,264,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	242,842,300.00	247,155,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,842,300.00	247,155,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,096,544.54	197,489,146.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,240,316.47	141,065,151.82
210101	Үндсэн цалин	89,540,564.40	101,655,058.08
210102	Нэмэгдэл	38,822,089.80	23,885,292.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,737,821.27	3,426,000.00
210104	Урамшуулал	8,139,841.00	12,098,801.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,572,072.07	18,701,975.50
210201	Тэтгэврийн даатгал	15,102,147.55	13,059,280.53
210202	Тэтгэмжийн даатгал	373,453.01	1,406,065.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	274,881.12	1,140,872.23
210204	Ажилгүйдлийн даатгал	74,690.62	285,293.08
210205	Эрүүл мэндийн даатгал	746,899.77	2,810,464.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,038,976.00	24,173,231.00
210301	Гэрэл, цахилгаан	1,298,651.00	1,016,091.00
210302	Түлш, халаалт	21,710,325.00	23,157,140.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,038,860.00	1,016,358.00
210401	Бичиг хэрэг	80,000.00	102,420.00
210402	Тээвэр, шатахуун	159,760.00	78,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	475,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	686,100.00	280,188.00
2105	Нормативт зардал	9,030,320.00	11,418,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,000.00	45,000.00
210502	Хоол, хүнс	8,559,120.00	10,423,890.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	449,200.00	949,940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	00.00
210604	Урсгал засвар	500,000.00	00.00

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	80,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	256,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,340,000.00	1,113,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	868,000.00	617,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	472,000.00	496,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,745,755.46	49,665,853.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,548,600.00	27,892,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,979,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,548,600.00	4,912,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	46,197,155.46	21,773,653.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,197,155.46	21,773,653.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	600,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	600,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-600,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	219,862,800.0	198,089,146.3	21,773,653.7	90.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	219,862,800.0	198,089,146.3	21,773,653.7	90.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,862,800.0	198,089,146.3	21,773,653.7	90.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,481,700.0	141,065,151.8	8,416,548.2	94.4
210101	Үндсэн цалин	95,179,200.0	101,655,058.1	(6,475,858.1)	106.8
210102	Нэмэгдэл	33,527,500.0	23,885,292.5	9,642,207.5	71.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,280,000.0	3,426,000.0	1,854,000.0	64.9
210104	Урамшуулал	15,495,000.0	12,098,801.3	3,396,198.7	78.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,180,000.0	18,701,975.5	1,478,024.5	92.7
210201	Тэтгэврийн даатгал	14,200,800.0	13,059,280.5	1,141,519.5	92.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,494,900.0	1,406,065.3	88,834.7	94.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,195,800.0	1,140,872.2	54,927.8	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	299,000.0	285,293.1	13,706.9	95.4
210205	Эрүүл мэндийн даатгал	2,989,500.0	2,810,464.3	179,035.7	94.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,764,100.0	24,173,231.0	4,590,869.0	84.0
210301	Гэрэл, цахилгаан	2,903,300.0	1,016,091.0	1,887,209.0	35.0
210302	Түлш, халаалт	25,660,800.0	23,157,140.0	2,503,660.0	90.2
210303	Цэвэр, бохир ус	200,000.0		200,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,040,000.0	1,616,358.0	1,423,642.0	53.2
210401	Бичиг хэрэг	100,000.0	102,420.0	(2,420.0)	102.4
210402	Тээвэр, шатахуун	200,000.0	78,750.0	121,250.0	39.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.0	475,000.0	(275,000.0)	237.5
210404	Ном, хэвлэл	50,000.0		50,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.0	80,000.0	220,000.0	26.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.0	880,188.0	1,309,812.0	40.2
2105	Нормативт зардал	16,286,000.0	11,418,830.0	4,867,170.0	70.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.0	45,000.0	-	100.0
210502	Хоол, хүнс	14,741,000.0	10,423,890.0	4,317,110.0	70.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	949,940.0	550,060.0	63.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.0	-	500,000.0	-
210604	Урсгал засвар	500,000.0		500,000.0	-
2107	Томилолт, зочны зардал	100,000.0	-	100,000.0	-
210702	Дотоод албан томилолт	100,000.0		100,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,511,000.0	1,113,600.0	397,400.0	73.7
210901	Бараа үйлчилгээний	950,000.0	617,600.0	332,400.0	65.0

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	бусад зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	561,000.0	496,000.0	65,000.0	88.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	219,862,800.0	219,862,800.0	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	190,598,700.0	190,598,700.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	190,598,700.0	190,598,700.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,264,100.0	29,264,100.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	29,264,100.0	29,264,100.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12.0	12.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	6.0	6.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.0	5.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,892,200.00	27,892,200.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,892,200.00	27,892,200.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,892,200.00	27,892,200.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,892,200.00	27,892,200.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,979,700.00	22,979,700.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,912,500.00	4,912,500.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,892,200.00	27,892,200.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,892,200.00	27,892,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,892,200.00	27,892,200.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхэд, багш, ажилтан, эцэг эх асран хамгаалагч бүр нээлттэй, шударга, хариуцлагатай байх, хүүхэд бүрийг хөгжүүлэхэд багш, эцэг эхийг бүтээлчээр оролцох боломжийг хангах, хүүхдийн сурч хүмүүжих орчныг аюулгүй байлгахыг зорилгоо болгон анхан шатны боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг юм.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын баг нь 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан, 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэн, дотоод хяналтын ажлын тайланг улирал бүр удирдлагад танилцуулан ажилласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Төв аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 2019, 2020 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 219,862.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,297.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,473.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 219,862.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 27,892.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 247,155.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 2,880.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 600.0 мянган төгрөгийн ном, нийт 3,480.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 600.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,880.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 12,340.2 мянган төгрөгийн, хандиваар 2,042.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 9,975.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 26,563.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 868,752.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	22,155.24	26,563.03	4,407.79
Үндсэн хөрөнгө	888,568.05	868,752.55	(19,815.50)
Нийт хөрөнгө	910,723.29	895,315.58	(15,407.71)
Өр төлбөр	36.00	-	(36.00)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	910,687.29	895,315.58	(15,371.71)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	910,723.29	895,315.58	(15,407.71)

Бараа материалын дансны үлдэгдэл 26,563.0 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 4,407.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 868,752.6 мянган төгрөг болж 19,815.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 895,315.6 мянган төгрөг болж 15,371.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 219,862.8 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 219,862.8 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 219,862.8 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 219,862.8 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 198,089.1 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 21,773.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 198,089.1 мянган төгрөг буюу 90.1 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 27,892.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгалд шилжүүлэгт 27,892.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 2,880.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 600.0 мянган төгрөгийн ном, нийт 3,480.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 600.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,880.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 4,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүүхдэд ээлтэй-эрүүл аюулгүй орчин”-ийг бүрдүүлж хөгжмийн танхимыг багш ажилчдын тусламжтайгаар тохижуулсан.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 20 нэр төрлийн 8,363.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 200.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг шийдвэрлэж данс бүртгэлд тусгаагүй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 4 нэр төрлийн 1,028.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж бүртгэлтэй, өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнаагүй НДШ-ийн 105.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлант онд батлагдсан төсвөөс төлж барагдуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 718.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Бодь тусгал Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил тайлант онд давтан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,864.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 272.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 9,591.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 272.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд 1 албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаалаар баталсан хувь хэмжээг нэмэгдүүлж 48.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Бараа материалын дансанд огт хөдөлгөөн ороогүй 119.7 мянган төгрөгийн хүнсний материал /төмс/ бүртгэлтэй, бодитоор оршин байгаа эсэх тооллогын баримтаар нотлогдохгүй байгаа нь: УСНББОУС 12, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.22-д “Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Хэмжилт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн тооллогоор дутаасан бараа материалыг холбогдох буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнаагүй НДШ-ийн 105.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлант онд батлагдсан төсвөөс төлж барагдуулсан нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх онд тайлагнаагүй НДШ-ийн өрийг тайлант оны батлагдсан төсвөөс төлснийг буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 20 нэр төрлийн 8,363.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 200.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. **Бараа материалын данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 4 нэр төрлийн 1,028.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоол, УСНББОУС 12-той тус туснийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж байх

3. **Шилэн данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэг	6	9,864.7	-	-	3	272.9	-	-	3	9,591.8

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn